

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

\\2016.07.25-2016.08.25\\

НЭГ:УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын Засаг даргын 2016 он 07 дугаар сарын 20-ны өдрийн А\83 дугаар захирамжаар өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг томилон захирамжийн биелэлтийг хангуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А\86 дугаар захирамжаар авто замын дагуу ариутгалын цэг ажиллаж байна.

08 дугаар сарын 05-ны өдөр Аймгийн хяналт, шинэжилгээ, үнэлгээний ажлын хэсэг ЗДТГ-ын эхний хагас жилийн ажлын тайлантай танилцан заавар, зөвлөмж өгч ажилласан.



ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2016 оны 08-р сарын 25-ны байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт \\мянган.төг\\	Зардлын гүйцэтгэл \\мянган.төг\\
1	ИТХ	28638,5	27098,5
2	ЗДТГ	181949,2	171950,7

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт \\мянган.төг\\	Зардлын гүйцэтгэл \\мянган.төг\\
1	Эрүүл мэндийн төв	179973,9	174968,7
2	Соёлын төв	31983,7	27532,3
3	3-р сургууль	461194,3	446194,3
4	3-р цэцэрлэг	225183,7	215065,3

ГУРАВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

3-Р СУРГУУЛЬ:

Бага ангийн багш нар 8 сарын 22-ноос ажилдаа орж анги танхимын цэвэрлэгээг хийж хичээлийн бэлтгэл ажил хангагдаад байна.

1. Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил хангаж дотуур байр, спорт заалны их цэвэрлэгээ болон гадна талбайн тохижилтыг хийж хогийн ургамлыг түүж цэвэрлэж дууслаа.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ :

- Эмнэлэгт хэвтсэн-31 үүнээс хүүхэд-5 халдварт-0 дотор-26
- Амбулаторийн үзлэг -296
- Урьдчилан сэргийлэх –58
- Дуудлага- 82

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 08 сарын 01 ний өдөр сумын ахмадын холбооны хурал, ШОХК-ны ахмадын зөвлөлийн уулзалтанд нийт 16 ахмад настанд “Эрүүл насжилт сэдэвт сургалтыг зохион байгуулан Ахмадын хийн дасгал Аэробекийн сургалтанд хамрагдах ахмадыг бүртгэн авсан.



08 сарын 01-07 ний дэлхий нийтээрээ Хүүхдийг эхийн сүүгээр хооллолтыг дэмжих өдрүүдийн хүрээнд иргэд болон 0-6 сартай хүүхэдтэй эхчүүдэд сургалтыг 21 хүнд зохион байгуулан гарын авлага тараан Эрүүл мэндийн төвийн Facebook групп хуудсанд мэдээлэл байршуулсан.



Шивээговь сумын эрүүл мэндийн төвөөс зохион байгуулсан “Ургамлын тоосны харшлаас урьдчилан сэргийлье” аяны хүрээнд “Илчлэг-Шивээ”, Эрүүл мэндийн төв байгууллагын эзэмшлийн талбайн шарилж, луулийн төрлийн хорт ургамлыг устган цэвэрлэх ажлыг 2016 оны 8-р сарын 16-нд хийж гүйцэтгэсэн.



ЗДТГ-тай хамтран 08 сарын 22-23-ны өдрүүдэд Говьсүмбэр аймгийн Төмөр замын ахмадын холбооны сургагч багшийг урьж сумын ахмадуудын дунд Хийн дасгал, аэробек дасгалын сургалтыг зохион байгуулан нийт 18 ахмадыг хамрууллаа.



ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Сумын ОНХСангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудын явцад аймгийн ГХБХБГазартай хамтран байнгын хяналт тавин ажиллаж байна. Сумын төвийн автозам дагуу тарьсан модыг хашаажуулах ажлын тендерт сонгон шалгарсан “Үлэм Тэмүүлэл” ХХК-тай шууд гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэж байна. Ажлын явц 35 хувьтай байна.



Нийтийн эзэмшлийн дэд бүтцийг сайжруулах \250 метр дулааны шугамыг солих ажил\-ын тендерт “Гом Илч” ХХК-тай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэж ажлын явц 90 хувьтай явагдаж байна.



Сумын “Хүндэтгэлийн хаалга” хийх ажлын тендерт “Макс Майнд” ХХК-тай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэж. Ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Ажлын явц 90 хувьтай явагдаж байна.



Цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажлыг “Чандмань” бүлэг 100 хувь гүйцэтгэж комисст хүлээлгэн өгөөд байна.



ТАВ. УЛСЫН БҮРТГЭЛ:

2016 оны 7 дугаар сарын 22-ноос 2016 оны 8 дугаар сарын 25-ны байдлаар Иргэний бүртгэлийн үйлчилгээг 65 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 20 иргэн бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.



2016 оны 8 дугаар сарын 20-ны байдлаар газраа анх удаа өмчилж авч байгаа 91 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна. Нийт 80 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг аймаг орохгүйгээр сумаасаа аваад байна.

Иргэдээс энэ сард Иргэний бүртгэлтэй холбоотой 73, газартай холбоотой 8, нийт 65 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэн ажилласан.

ЗУРГАА. МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ:

Сумын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцын мэдээг 08-р сарын 22-ны өдөр аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлээд байна.

Малын гоц халдварт шүлхий болон цэцэг өвчний талаарх мэдээллийг иргэн аж ахуйн нэгжид цаг тухайд нь хүргэж байна.



2016 оны 8 дугаар сарын 11-ний Боом, ДХХ-Энтербактериоз, Үхрийн дуут, Цусан халдварт, Гахайн ёлом, Шөвөг яр, Гахайн мялзан зэрэг вакцинууд таригдсан.

Хонины цэцэг өвчний вакцинд хамрагдсан малын бүртгэл

Д/д	Хугацаа	Вакцинд хамрагдсан өрхийн тоо	Вакцинд хамрагдсан малын тоо		
			Нийт	Үүнээс	
				Хонь	Хурга
1	2016.08.14- 2016.08.22	42	11799	9001	2798